



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|--|---|------------|-----|
| 127. | Элчин сайдыг тохоон томилох тухай | Дугаар 17 | 277 |
| МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ | | | |
| 128. | Журам шинэчлэн батлах тухай | Дугаар 394 | 278 |
| 129. | Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 398 | 291 |
| 130. | Журам батлах тухай | Дугаар 410 | 295 |
| 131. | Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай | Дугаар 411 | 299 |
| 132. | Журамд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 412 | 304 |
| 133. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 415 | 305 |
| 134. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 416 | 306 |
| 135. | Цөм сүргийн үржлийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 420 | 327 |
| 136. | Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2014 оны хэмжээг тогтоох тухай | Дугаар 423 | 327 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 02 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Швейцарын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лувсанцэрэнгийн Оргилыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Швейцарын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаа Ваанчигийн Пүрэвдоржийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 394

Улаанбаатар
хот

**Журам шинэчлэн
батлах тухай**

“Үндэсний үйлдвэрлэгчийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоол, “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол баталсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 221 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, “Журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 48 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД**

Х.БАТТУЛГА



Засгийн газрын 2013 оны 394 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ХОНИНЫ НООС, ТЭМЭЭНИЙ НООС БЭЛТГЭЖ ҮНДЭСНИЙ
ҮЙЛДВЭРТ ТУШААСАН ХОРШООНЫ ГИШҮҮН МАЛЧИН,
МАЛ БҮХИЙ ЭТГЭЭДЭД МӨНГӨН УРАМШУУЛАЛ
ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үргэлж-хэвийн ангиллын ноос боловсруулдаг үндэсний үйлдвэр (үйлдвэр, цех зэрэг)-т тушаасан хоршооны гишүүн* малчин, мал бүхий этгээд (цаашид “малчин, мал бүхий этгээд” гэх)-д мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайллагнатай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Ноос боловсруулдаг үндэсний үйлдвэр (цаашид “үйлдвэр” гэх)-т хонь, тэмээний ноос нийлүүлсэн малчин, мал бүхий этгээдэд урд оны жилийн эцсээр тоологдсон малын А данс дахь хонь, тэмээний тоо болон ноосны гарцын стандартыг үндэслэн урамшуулал олгоно.

1.3. Үйлдвэр нь ноосыг самнах эсхүл дараа (ээрэх, нэхэх, сүлжих)-гийн шатны боловсруулалт хийх эсхүл хивс, эсгий, эсгий бүтээгдэхүүн хийх зэрэг дагнасан болон цогц технологи бүхий эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байна.

1.4. Үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулалт олгох талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, энэхүү журмыг тухайн нутаг дэвсгэртээ сурталчлах, энэ чиглэлээр малчдад сургалт явуулах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

Хоёр. Урамшуулалт хамрагдах малчин, мал бүхий этгээд болон ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоонд тавигдах шаардлага

2.1. Малчин, мал бүхий этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. хонь болон тэмээг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд технологит хугацаанд тогтмол хамруулсан байх;

2.1.2. энэхүү журмын 1.2-т заасан стандартын шаардлагыг хангасан ноосыг төрлөөр нь 50-100 кг-аар савлаж бэлтгэх;

2.1.3. энэ журмын 3.3-т заасан баримтад өөрийн харилцах банкны нэр, дансныхаа дугаарыг бичиж, малчин өрхийн баталгааны тэмдэг*-ээр баталгаажуулна.

*Тайлбар: Энэхүү журамд заасан “хоршооны гишүүн” гэснийг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*Тайлбар: Энэхүү журамд байгаа “малчин өрхийн баталгааны тэмдэг” гэсэн тодотголыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2.2. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо (цаашид “холбоо” гэх) нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.2.1. үйлдвэрийн жагсаалтыг жил бүрийн 4 дүгээр сард багтаан баталж, олон нийтэд зарлах;

2.2.2. энэхүү журамд заасан баримтын загварыг 2002 оны Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан “Загвар батлах тухай” 171/111 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Бараа материалын тооцооны баримт”-ын загварт нийцүүлэн холбогдох мэдээлэл, ялгах тэмдэглэгээг тусгаж хэрэглэх;

2.2.3. үйлдвэрийн төлөөлөгчид итгэмжлэл олгох;

2.2.4. худалдан авсан ноосонд чанарын тордолт хийх, гарах хохирлыг бүрэн хариуцах гэрээг үйлдвэрийн төлөөлөгчтэй байгуулж ажиллуулах;

2.2.5. энэхүү журмын 2.2.2-т заасан баримтын маягтыг хуваарилах, олгох, тооцох.

Гурав. Урамшуулалт олгох

3.1. Урамшууллын мөнгийг Монголбанкинд “Малчин” данс нээж, Монголбанкаас тухайн малчин, мал бүхий этгээдийн банкин дахь дансанд шилжүүлж олгоно.

3.2. Малчин, мал бүхий этгээд нь данс бүхий банкиндаа хүсэлт гаргах эсхүл шинээр данс нээлгэх болон тухайн арилжааны банкны салбар холбогдох мэдээллийг банкны төвд, банкны төв нь Монголбанкинд тус тус хүргүүлнэ.

3.3. Үйлдвэр (ноос бэлтгэлийн төлөөлөгч) нь малчин, мал бүхий этгээдээс ноос хүлээн авахдаа баримтыг З хувь үйлдэж, малчин, мал бүхий



этгээдээр энэ журмын 3.2-т заасан дансыг нь бичүүлэн 2 хувийг малчин, мал бүхий этгээдэд, 1 хувийг өөртөө үлдээнэ.

3.4. Малчин, мал бүхий этгээд нь урамшуулалд хамрагдах хүсэлтээ энэхүү журмын 3.3-т заасан баримтын 1 хувийг хавсарган сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасагт өгнө.

3.5. Сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасгийн ажилтан нь ноос хүлээн авсан баримтыг үндэслэн малчин, мал бүхий этгээдийн хаяг, малын тоо, тушаасан ноосны хэмжээ, төрөл зэргийг гарган сум, дүүргийн Засаг даргаар баталгаажуулж холбогдох материалыг аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар (цаашид “хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар” гэх)-т жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний дотор хүргүүлнэ.

3.6. Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь сум, дүүргээс ирүүлсэн материалыг бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн холбогдох мэдээлэлтэй тулган нэгтгэж, холбогдох материалыг тухайн жилийн 9 дүгээр сарын 15-ны дотор Мал хамгаалах санд хүргүүлнэ.

3.7. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо нь гишүүн үйлдвэр тус бүрээс ноос худалдан авсан тухай бүртгэл, чанар шалгагчийн дүгнэлтийг авч нэгтгэн баталгаажуулж тухайн жилийн 9 дүгээр сарын 25-ны дотор Мал хамгаалах сангийн “Цахим бүртгэлийн систем”-рүү илгээнэ.

3.8. Мал хамгаалах сан нь энэхүү журмын 3.6, 3.7-д заасан материалыг харьцуулан хянаж, үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулалт олгох асуудлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

3.9. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь уг танилцуулгыг үндэслэн урамшуулалт олгох шийдвэр гаргаж, Сангийн яам дахь Төрийн сан, Монголбанкинд тус тус хүргүүлнэ.

3.10. Төрийн сан энэхүү журмын 3.9-д заасан шийдвэрийг үндэслэн урамшуулалд шаардагдах хөрөнгийг Мал хамгаалах сангийн данснаас Монголбанк дахь “Малчин” дансанд шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор шилжүүлнэ.

3.11. Монголбанк нь банкны төвөөс ирүүлсэн малчин, мал бүхий этгээдийн дансны талаархи мэдээллийг “Урамшуулалт олгох тухай” хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэртэй тулгаж,

нягталсны үндсэн дээр малчин, мал бүхий этгээдэд олгох урамшууллын мөнгийг дээр дурдсан банкинд ажлын 1 өдөрт багтаан шилжүүлнэ.

3.12. Малчин, мал бүхий этгээдийн банкны нэр, дансны дугаар, регистрийн дугаар зөрсөн эсхүл урамшуулалт авах зорилгоор банкинд давхар данс нээлгэсэн зөрчил ирүүлсэн тохиолдолд Монголбанк урамшууллын мөнгийг шилжүүлэхгүй бөгөөд холбогдох мэдээллийг банк болон Мал хамгаалах сангаас шаардана.

3.13. Малчин, мал бүхий этгээдийн харилцагч банк нь Монголбанкнаас шаардсаны дагуу банкны нэр, дансны дугаар, регистрийн дугаарын талаар шинэчилсэн мэдээллийг ажлын 3 хоногт багтаан хүргүүлнэ.

3.14. Малчин, мал бүхий этгээдийн материалд байгаа зөрчлийн тухай мэдээлэл болон уг зөрчлийг хэрхэн арилгах тухай мэдэгдлийг Мал хамгаалах сангаас тухайн аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газарт, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасагт ажлын 3 хоногт багтаан хүргүүлнэ.

3.15. Сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг нь мэдэгдэл хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногт багтаан зөрчлийг арилгаж, аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газраар уламжлуулан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

3.16. Мал хамгаалах сан нь 3.15-д заасан хугацаанд багтаан ирүүлсэн материалыг хүлээн авсанаас хойш ажлын 3 хоногт багтаан Монголбанкннд хүргүүлнэ.

3.17. Монголбанк нь банк болон Мал хамгаалах сангаас ирүүлсэн мэдээллийг хүлээн авсанаас хойш энэхүү журмын 3.11-т заасан хугацаанд тухайн малчны харилцах банк руу шилжүүлнэ.

Дөрөв. Урамшуулалт олгохоос татгалзах үндэслэл

4.1. Энэхүү журмын 2.1-д заасан шаардлагыг хангаагүй, материал хүлээн авах хугацаанаас хоцроосон, буруу ташаа мэдээ ирүүлсэн, холбогдох материалыг бүрэн ирүүлээгүй, баримт бичигт засвар хийсэн малчин, мал бүхий этгээдийн материалыг сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасгийн ажилтан хүлээн авахаас татгалзаж буцаана.

4.2. Энэхүү журмын 3.15-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг шинэчлэн ирүүлээгүй тохиолдолд урамшуулалт олгохгүй.



4.3. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 6.4.2-т заасан жагсаалтад орсон болон мэдээлэл ирүүлэгэй үйлдвэрийг нийтэд мэдээлж, аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар, холбоонд хүргүүлнэ.

4.4. Мал хамгаалах сан нь энэхүү журмын 4.3-т заасан үйлдвэрт ноосоо тушаасан малчинд урамшуулалт олгохгүй.

Тав. Урамшуулалт олгох хөрөнгийг төлөвлөх

5.1. Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь мал тооллогын дүн, сүргийн эргэлтэд үндэслэн харьяа нутаг дэвсгэртээ дараа жилд бэлтгэн нийлүүлэх боломжтой хонь, тэмээний ноосны хэмжээ, нутаг дэвсгэртээ байгаа үйлдвэрийн жагсаалт, тэдгээрийн хучин чадлыг сум, дүүргэ тус бүрээр гаргаж, жил бүрийн II улиралд багтаан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

5.2. Холбоо нь үйлдвэр тус бүрийн дараа жил худалдан авах ноосны хэмжээг нэр, төрлөөр гаргуулж нэгтгэн жил бүрийн II улиралд багтаан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

5.3. Мал хамгаалах сан нь энэхүү журмын 5.1, 5.2-т заасан мэдээллийг харьцуулан судалж, дараа жил үйлдвэрт ноосоо тушаах хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгох урамшууллын хэмжээг төлөвлөн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусгуулах санал тавина.

Зургаа. Тайллагнах, хяналт тавих

6.1. Үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулалт олгох талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, малчдад урамшуулалт олгох ажилд сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.

6.2. Улсын хэмжээнд энэхүү журмын хэрэгжилтэд хөдөө аж ахуйн болон төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

6.3. Урамшуулалт олгох үйл ажиллагааг дараах байдлаар тайллагнана:

6.3.1. Монголбанк нь урамшууллын мөнгө олгож байгаа банктай тооцоо нийлж, тайланг 12 дугаар сарын 20-ны дотор Мал хамгаалах санд хүргүүлнэ;

6.3.2. Төрийн сангаас ноосны урамшуулалд олгосон санхүүжилт нь арилжааны банкинд шилжүүлэх мөнгөнөөс илүү гарсан тохиолдолд үлдэгдэл мөнгийг Төрийн сан дахь Мал хамгаалах сангийн дансанд буцаана;

6.3.3. Мал хамгаалах сан нь тухайн онд урамшуулалд хамрагдсан малчин, мал бүхий этгээдийн бүртгэл, хөрөнгийн зарцуулалтын талаархи мэдээ, тайланг дараа оны 1 дүгээр сарын 30-ны дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

6.3.4. Мал хамгаалах сан нь жил бүр урамшуулалд шаардагдах хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайланд дараа оны II улиралд багтаан аудит хийлгүүлнэ;

6.3.5. Мал хамгаалах сан нь урамшуулалт олгох асуудлыг төлөвлөх, олгох асуудалтай холбоотой материал, мэдээлэл, тайланг архивын нэгж болгон хадгална.

6.4. Үйлдвэр худалдан авсан ноосоороо эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа эсэхийг дараах байдлаар хянана:

6.4.1. холбоо нь үйлдвэр бүр худалдан авсан ноосоороо эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа явцтай улирал бүр танилцаж, тайланг дараа оны 6 дугаар сарын 1-ний дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

6.4.2. холбоо үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүний мэдээллээ ирүүлээгүй үйлдвэрийн нэрийг нийтэд мэдээлж, мэдээллийг нөхөн авч нэгтгэн 6 дугаар сарын 15-ны дотор багтаан хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.5. Үйлдвэр нь малчин, мал бүхий этгээдээс ноос худалдан аваахдаа зах зээлийн үнийг баримталж байгаа эсэхэд холбоо хяналт тавина.

Долоо. Хариуцлага

7.1. Үйлдвэр хуурамч мэдээлэл гаргаж өгсөн эсхүл тогтоосон хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлээгүйгээс малчин, мал бүхий этгээдэд учирсан хохирлыг уг үйлдвэр бүрэн хариуцна.

7.2. Үйлдвэр малчин, мал бүхий этгээдийн нийлүүлсэн ноосны хэмжээ, чанар, ангиллын талаар буруу мэдээ ирүүлсэн, худал баримт бүрдүүлж өгсөн тохиолдолд тухайн үйлдвэрийн гаргасан бусад



баримтыг мөн адил хүлээн авахгүй бөгөөд зээл болон бусад дэмжлэгт хамруулахгүй.

7.3. Малчин, мал бүхий этгээдийн бэлтгэсэн ноосонд ариун цэврийн хуурамч гэрчилгээ олгосон хувийн мал эмнэлгийн нэгжийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасч, хохирлыг нөхөн төлүүлнэ. Малчин нь өрхийн баталгааны тэмдгийг бусдад ашиглуулахгүй байхыг бүрэн хариуцна.

7.4. Ноосны урамшуулалт хариуцсан ажилтан нь урамшуулалтай холбоотой мэдээллийг цахим бүртгэлийн системд буруу оруулсан, засварласан тохиолдолд үүнээс үүдэн гарах хохирлыг бүрэн хариуцна.

Засгийн газрын 2013 оны 394 дүгээр
тогтооолын 2 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРТ АРЬС,
ШИР БЭЛТГЭН ТУШААСАН ХОРШООНЫ ГИШҮҮН
МАЛЧИН, МАЛ БҮХИЙ ЭТГЭЭДЭД МӨНГӨН
УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Арьс, ширийг гүн боловсруулах үндэсний үйлдвэр (цех, төв, цэг зэрэг)-т (цаашид “үйлдвэр” гэх) арьс, ширийг стандартын дагуу бэлтгэн тушаасан, малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн* малчин, мал бүхий этгээдэд (цаашид “малчин, мал бүхий этгээд” гэх) мөнгөн урамшуулалт олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. “Арьс, ширийг гүн боловсруулдаг үйлдвэр” гэдэгт арьс, ширийг хатаах боловсруулалт хийсний дараа элдэж зөвлрүүлэн гүйцэд боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэр хамаарна.

1.3. Үйлдвэрт арьс, шир тушаасан малчинд мөнгөн урамшуулалт олгох талаархи хууль тогтоомж, журмыг тухайн нутаг дэвсгэртээ сурталчлах, малчдад сургалт явуулах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

Хоёр. Урамшуулалтад хамрагдах малчин, мал бүхий
этгээдэд тавигдах шаардлага

2.1. Малчин, мал бүхий этгээдэд дараах шаардлага тавигдана:

2.1.1. малаа бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд технологийн хугацаанд нь тогтол хамруулсан, эрүүл болохыг баталгаажуулсан эрүүл мэндийн гэрчилгээ авах;

2.1.2. өөрийн харилцах банкны нэр, дансны дугаараа арьс, шир бэлтгэлийн баримтад зөв, гаргацтай бичиж, малчин өрхийн баталгааны тэмдэг* дарах;

2.1.3. энэхүү журмын 3.1.1-д заасан жагсаалтад багтсан үйлдвэрт арьс, ширээ тушаах.

Гурав. Урамшуулалт олгох үйл ажиллагаанд Монголын арьс, ширний үйлдвэрлэлийн холбооны оролцоо

3.1. Монголын арьс, ширний үйлдвэрлэлийн холбоо (цаашид “холбоо” гэх) нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

*Тайлбар: Энэхүү журамд заасан “Малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн” гэснийг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

*Тайлбар: Энэхүү журамд байгаа “малчин өрхийн баталгааны тэмдэг” гэсэн тодотголыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

3.1.1. арьс, ширийг гүн боловсруулдаг үйлдвэрийн жагсаалтыг жил бүрийн 8 дугаар сард баталж, олон нийтэд зарлах;

3.1.2. энэхүү журамд заасан баримтын загварыг 2002 оны Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан “Загвар батлах тухай” 171/111 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Барaa материалын тооцооны баримт”-ын загварт нийцүүлэн холбогдох мэдээлэл, ялгах тэмдэглэгээг тусгаж хэрэглэх;

3.1.3. холбооны болон мал бэлтгэлийн төлөөлөгчид итгэмжлэл олгох;

3.1.4. худалдан авсан арьс, ширэнд чанарын тордолт хийх, гарах хохирлыг бүрэн хариуцах гэрээг холбооны төлөөлөгчтэй байгуулж ажиллуулах;

3.1.5. энэхүү журмын 3.1.2-т заасан баримтын маягтыг хуваарилах, олгох, тооцох.



Дөрөв. Урамшуулал олгох

4.1. Малчин, мал бүхий этгээд нь өөрийн харилцагаа банкиндаа хүсэлт гаргах эсхүл шинээр данс нээлгэх болон тухайн банкны салбар холбогдох мэдээллийг банкны төвд, банкны төв нь Монголбанкинд тус тус хүргүүлнэ.

4.2. Орон нутаг дахь Монголын арьс, ширний үйлдвэрлэлийн холбооны төлөөлөгч (цаашид “холбооны төлөөлөгч” гэх), мал бэлтгэлийн төлөөлөгч, малчнаас арьс, шир эсхүл бэлтгэлийн мал хүлээн авахдаа баримтад энэхүү журмын 4.1-д заасан дансыг бичүүлж, малчин өрхийн баталгааны тэмдгээр баталгаажуулан 3 хувь үйлдэж 1 хувийг өөртөө, 2 хувийг малчин, мал бүхий этгээдэд хүлээлгэн өгнө.

4.3. Малчин, мал бүхий этгээд нь мал бэлтгэлийн төлөөлөгчид мал худалдаа тохиолдолд малыг нядалсны дараа арьс, ширийг үндэсний үйлдвэр эсхүл холбооны төлөөлөгчид нийлүүлэх нөхцөлийг гэрээндээ тусгана.

4.4. Мал бэлтгэлийн төлөөлөгч нь арьс, ширийг чанар байдлыг нь алдагдуулалгүйгээр баримтын хамт үйлдвэрт эсхүл холбооны төлөөлөгчид тушаана.

4.5. Малчин, мал бүхий этгээд нь энэхүү журмын 4.2-т заасан баримтын 1 хувийг сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасгийн ажилтанд өгнө.

4.6. Сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасгийн ажилтан баримтыг малчин, мал бүхий этгээдээс хүлээн авч, хаяг, малын тоо, бүртгэлийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй тулган, тушаасан арьс, ширний болон худалдан борлуулсан малын төрөл, тоо хэмжээг нэгтгэн сум, дүүргийн Засаг даргаар баталгаажуулж холбогдох материалыг аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газарт жил бүрийн 7 дугаар сарын 15-ны болон 1 дүгээр сарын 15-ны дотор хоёр удаа хүргүүлнэ.

4.7. Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь сум, дүүргээс ирүүлсэн материалыг бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон анхан шатны баримттай тулган нэгтгэж, аймгийн хэмжээний материалыг 8 дугаар сарын 15-ны болон 2 дугаар сарын 15-ны дотор жилд хоёр удаа Мал хамгаалах санд хүргүүлнэ.

4.8. Холбоо нь үйлдвэр тус бүрээс арьс, шир худалдан авсан бүртгэл болон баримтыг нэгтгэн жил бүрийн 8 дугаар сарын 15-ны болон 2 дугаар сарын 15-ны дотор жилд хоёр удаа Мал хамгаалах санд хүргүүлнэ.

4.9. Мал хамгаалах сан нь аймаг, нийслэл болон холбооноос ирүүлсэн материалыг харьцуулан хянаж, үндэсний үйлдвэрт стандартын дагуу бэлтгэсэн арьс, шир тушаасан малчинд урамшуулал олгох асуудлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

4.10. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн урамшуулал олгох шийдвэрийг гаргаж, Сангийн яам дахь Төрийн сан, Монголбанкинд тус тус хүргүүлнэ.

4.11. Төрийн сан урамшуулалд шаардагдах мөнгийг энэхүү журмын 4.10-т заасан шийдвэрийг хүлээн авсанаас хойш ажлын 3 хоногт багтаан Мал хамгаалах сангийн данснаас Монголбанк дахь “Малчин” дансанд шилжүүлнэ.

4.12. Монголбанк банкны төвөөс ирүүлсэн малчны дансны мэдээллийг энэхүү журмын 4.11-д заасан хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэртэй тулгаж, урамшууллын мөнгийг банкинд 1 хоногийн дотор шилжүүлнэ.

4.13. Малчин, мал бүхий этгээдийн банкны нэр, дансны дугаар, регистрийн дугаар зөрсөн эсхүл урамшуулал авах зорилгоор банкинд давхар данс нээлгэсэн зөрчил илрүүлсэн тохиолдолд Монголбанк урамшууллын мөнгийг шилжүүлэхгүй бөгөөд холбогдох мэдээллийг банк болон Мал хамгаалах сангаас шаардана.

4.14. Малчин, мал бүхий этгээдийн харилцагч банк нь Монголбанкаас шаардсаны дагуу банкны нэр, малчны дансны дугаарын талаар шинэчилсэн мэдээллийг ажлын 3 хоногт багтаан хүргүүлнэ.

4.15. Малчин, мал бүхий этгээдийн материалд байгаа зөрчлийн тухай мэдээлэл болон уг зөрчлийг хэрхэн арилгах талаархи мэдэгдлийг Мал хамгаалах сангаас тухайн аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газарт, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасагт ажлын 3 хоногт багтаан хүргүүлнэ.

4.16. Сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг нь мэдэгдэл хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногт багтаан зөрчлийг арилгаж, аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газраар уламжлуулан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

4.17. Мал хамгаалах сан нь энэхүү журмын 4.16-д заасан хугацаанд багтаан ирүүлсэн материалыг хүлээн авсанаас хойш ажлын 3 хоногт багтаан Монголбанкинд хүргүүлнэ.



4.18. Монголбанк нь банк болон Мал хамгаалах сангаас ирүүлсэн мэдээллийг хүлээн авсанаас хойш энэхүү журмын 4.12-т заасан хугацаанд тухайн малчны харилцах банк руу шилжүүлнэ.

Тав. Урамшуулал олгохоос татгалзах үндэслэл

5.1. Малчин, мал бүхий этгээд нь энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд урамшуулал олгохгүй.

5.2. Энэхүү журмын 4.17-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг шинчлэн ирүүлээгүй малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгохгүй.

Зургаа. Урамшуулал олгох хөрөнгийг төлөвлөх

6.1. Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь мал сүргийн эргэлтэд үндэслэн дараа жил бэлтгэн нийлүүлэх боломжтой бэлтгэлийн мал болон арьс, ширний төрөл, тоо хэмжээ, тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа үйлдвэрийн жагсаалт, тэдгээрийн хүчин чадлыг сум, дүүрэг тус бүрээр гаргаж, жил бүрийн II улиралд багтаан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

6.2. Холбоо нь үйлдвэр тус бүрийн дараа жил худалдан авах арьс, ширний төрөл, тоо хэмжээг үйлдвэрлэлийн хүчин чадалд нь нийцүүлэн гаргаж нэгтгэн жил бүрийн II улиралд багтаан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

6.3. Мал хамгаалах сан нь тухайн жилийн сүргийн бүтэц болон энэхүү журмын 6.1, 6.2-т заасан мэдээллийг харьцуулан судалж, дараа жил үйлдвэрт нийлүүлэгдэх арьс, ширний төрөл, тоо хэмжээг тодорхойлно.

6.4. Мал хамгаалах сан нь энэхүү журмын 6.3-т заасныг үндэслэн малчин, мал бүхий этгээдэд олгох урамшууллын санхүүжилтийг төлөвлөж, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусгуулах санал тавина.

Долоо. Тайлагнах, хяналт тавих

7.1. Урамшууллын мөнгө олголтыг дараах байдлаар тайлagnана:

7.1.1. урамшууллын мөнгө нь банкинд шилжүүлэх мөнгнөөс илүү гарсан тохиолдолд Монголбанк үлдэгдэл мөнгийг Төрийн сан дахь Мал хамгаалах сангийн дансанд буцаана;

7.1.2. Монголбанк нь урамшууллын мөнгө олгож байгаа банктай тооцоо нийлж, тайланг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний болон 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор тус тус Мал хамгаалах санд хүргүүлнэ;

7.1.3. үйлдвэр нь худалдан авсан арьс, ширний талаархи мэдээ, холбогдох баримтыг нэгтгэн холбоонд энэхүү журмын 4.8-д заасан хугацаанд багтаан хүргэнэ;

7.1.4. Мал хамгаалах сан нь тухайн онд урамшуулалд хамрагдсан малчны бүртгэл, хөрөнгийн зарцуулалтын талаархи мэдээ, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний болон 7 дугаар сарын 1-ний дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ;

7.1.5. Мал хамгаалах сан нь жил бүр урамшуулалд зарцуулсан хөрөнгө, санхүүгийн тайланд аудит хийлгүүлнэ;

7.1.6. Мал хамгаалах сан нь урамшуулал олгох асуудлыг төлөвлөх, олгохтой холбоотой материал, мэдээлэл, тайланг архивын нэгж болгон хадгална.

7.2. Урамшууллын мөнгө олголтыг дараах байдлаар хянана:

7.2.1. тухайн нутаг дэвсгэрт малчдад мөнгөн урамшуулал олгох үйл ажиллагаанд сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина;

7.2.2. улсын хэмжээнд энэхүү журмын хэрэгжилтэд хөдөө аж ахуйн болон төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана;

7.2.3. үйлдвэр нь малчин, мал бүхий этгээд болон мал бэлтгэлийн төлөөлөгчөөс арьс, шир худалдан авахдаа зах зээлийн үнийг баримталж байгаа эсэхэд холбоо хяналт тавина;

7.2.4. холбоо худалдан авсан арьс, ширэнд чанарын тордолт хийх, гарах хохирлыг бүрэн хариуцах гэрээг холбооны төлөөлөгчтэй байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

7.3. Үйлдвэр худалдан авсан арьс, ширээр гүн боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа эсэхийг дараах байдлаар хянана:

7.3.1. холбоо нь үйлдвэр тус бүр худалдан авсан арьс, ширээр гүн боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж



байгаа явцтай улирал бүр танилцаж, тайланг дараа оны 6 дугаар сарын 1-ний дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

7.3.2. холбоо арьс, ширээр гүн боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн мэдээллээ ирүүлээгүй үйлдвэрийн нэрийг нийтэд мэдээлж, мэдээллийг нөхөн авч нэгтгэн 6 дугаар сарын 15-ны дотор багтаан хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Найм. Хариуцлага

8.1. Малчин, мал бүхий этгээдийн нийлүүлсэн арьс, ширний нэр төрөл, тоо хэмжээний талаар буруу ташаа мэдээ гаргасан, баримтыг засварласан үйлдвэрт хөнгөлөлтэй зээл дахин олгохгүй бөгөөд хохирлыг хуулийн дагуу нөхөн төлүүлнэ.

8.2. Малчинд арьс, шир бэлтгэсэн тухай хуурамч гэрчилгээ олгосон мал эмнэлэг, үржлийн нэгжийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасч, хохирлыг нөхөн төлүүлнэ. Малчин нь өрхийн баталгааны тэмдгийг бусдад ашиглуулахгүй байхыг бүрэн хариуцна.

8.3. Урамшууллын материалыг нэгтгэх, хянах явцад албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болж алдаа дутагдал гарсан тохиолдолд гарсан хохирлыг холбогдох хуулийн дагуу буруутай этгээд хариуцна.

8.4. Үйлдвэр хуурамч мэдээлэл гаргаж өгсөн эсхүл тогтоосон хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлээгүйгээс малчин, мал бүхий этгээдэд учирсан хохирлыг уг үйлдвэр бүрэн хариуцна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 398

Улаанбаатар
хот

**Тогтоол, тогтоолын хавсралтад
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын “Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 2012 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтын “ж” хэсэгт “2. Шинжлэх ухааны бодлого, зохицуулалтын газар” гэж нэмсүгэй.

2. Засгийн газрын “Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 2012 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтын “ж” хэсгийн “2, 3, 4” гэсэн дугаарлалтыг “3, 4, 5” гэж өөрчилсүгэй.

3. Засгийн газрын “Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 2012 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтын “ж” хэсгийн “3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын “шинжлэх ухааны хэлтэстэй”” гэснийг хүчингүй болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т оруулах өөрчлөлтийг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.САЙХАНБИЛЭГ

Засгийн газрын 2013 оны 398 дугаар
тогтоолын хавсралт

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН
ХӨТӨЛБӨРТ ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1. “2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт хэсэгт дор дурдсан нэмэлт оруулах:

2.4.1¹. Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар судалгаа, бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, бодлогын удирдамжаар хангах.”

2. “2.5. Үйл ажиллагааны гол зорилт хэсэгт дор дурдсан нэмэлт оруулах:




2.5.1¹. Үйл ажиллагааны стратегийн 1¹ дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1¹.1. шинжлэх ухааны талаархи хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийг шинэчлэх төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах;

2.5.1¹.2. шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалт, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого, шийдвэрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;

2.5.1¹.3. шинжлэх ухаан, технологийн хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, шинжлэх ухааны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, удирдлага, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох ажлыг зохицуулах.”

3. Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратегийн загварт дор дурдсан өөрчлөлт оруулах:



4. “3.3. Зохион байгуулалтын бүтэц хэсэгт дор дурдсан нэмэлт оруулах:

3.3.1¹ шинжлэх ухааны бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр¹ (дэд хэсэг) зорилтын хүрээнд шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар судалгаа, бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн болон төсөв, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар


хангах үндсэн үүрэг хүлээж, шинжлэх ухааны талаархи хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийг шинэчлэх төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах, шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалт, салбарын хүний нөөцийн бодлого, шийдвэрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангахад бүх талын дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь сайдын эрхлэх асуудлын хүрээний шинжлэх ухааныг хөгжүүлэх, салбарын удирдлагын менежмент, хүний нөөц, эдийн засгийн бодлогын шинэчлэлийн баримт бичгүүд, хууль тогтоомжийн үзэл баримтлал, урт, дунд, богино хугацааны бодлого, стратеги, мастер төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулах, олон нийтээр хэлэлцүүлэх, холбогдох байгууллагаар батлуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, шинжлэх ухааны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, удирдлага, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох ажлыг зохицуулах, салбарыг бодлогын удирдамжаар хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийн эрэлтэд сууринсан шинжлэх ухаан, технологийн хөгжлийн оновчтой тогтолцоог бий болгох, үр дүнд сууринсан эрдэм шинжилгээ, судалгааг хэрэгжүүлэх, шинжлэх ухааны өрсөлдөх чадварыг бий болгож, мэдлэгт сууринсан эдийн засгийн хөгжлийг хөтлөх үндэсний чадамжийг бурдүүлэх, шинжлэх ухааны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгаа, хөгжлийг хангахад чиглэгдэнэ.

Энэ нэгжийн удирдлага, ажилтнууд нь багаар ажиллаж ажлын байран дээр суралцахын зэрэгцээ бусад яамны зохион байгуулалтын ижил төрлийн бүтцийн нэгжийн удирдлага, ажилтнуудтай ажил төрөл, мэдлэг, ур чадвараа өсгөх чиглэлээр хамтран ажиллаж, аливаа асуудлыг зөвхөн салбарын төдийгүй, улсын хэмжээнд тогтолцооны онолд тулгуурлан асуудалд хандан ажиллаж, сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн даргад зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

Энэ нэгжийн үндсэн үйлчлүүлэгч нь сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн, судлаач, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага байна.

5. Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны бүтцийн тогтолцооны ерөнхий загварыг дор дурдсанаар өөрчлөх:



6. Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.4.1-ийн “шинжлэх ухаан, технологи”, 2.4.3, 2.5.1.3, 2.5.3.1, 3.3.-ын нэг, хоёрдугаар өгүүлбэрийн “шинжлэх ухааны”, “шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагыг”, 3.3.-ын “шинжлэх ухаан, технологийн хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, шинжлэх ухааны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, удирдлага, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох ажлыг зохицуулах, нийгэм, эдийн засгийн хөгжлийн эрэлтэд сууриссан шинжлэх ухаан, технологийн хөгжлийн оновчтой тогтолцоог бий болгох, үр дүнд сууриссан эрдэм шинжилгээ, судалгааг хэрэгжүүлэх, шинжлэх ухааны өрсөлдөх чадварыг бий болгож, мэдлэгт сууриссан эдийн засгийн хөгжлийг хөтлөх үндэсний чадамжийг бүрдүүлэх, шинжлэх ухааны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгаа, хөгжлийг хангахад” гэснийг тус тус хасах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 410

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхэд, залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар (Ц.Жадамба)-т, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Х.ТЭМҮҮЖИН

Засгийн газрын 2013 оны 410 дугаар
тогтоолын хавсралт

**ЦАХИМ ТОГЛООМЫН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь цахим тоглоомын газрын үйлчилгээ эрхэлж байгаа болон шинээр эрхлэх иргэд, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлагыг тогтоох, бүртгэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалахад оршино.

1.2. Цахим тоглоомын газрын үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээд нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Интернет, компьютер болон сүлжээний технологи ашиглан тоглоом тоглуулах үйлчилгээг цахим тоглоомын газар гэнэ.

2. Ажлын байрны шаардлага

2.1. Интернэт кафе, цахим тоглоомын үйлчилгээний газрууд тусдаа үйл ажиллагаа явуулах бөгөөд ажлын байр нь үйлчилгээ үзүүлэх таатай орчинг бүрдүүлж, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл нь эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулсан байна.



2.2. Үйлчилгээ үзүүлж байгаа стандарт шаардлага хангасан ажлын байр нь гадна талдаа хаяг, цагийн хуваарийг байршуулсан байх ба бүртгэлийн гэрчилгээ, ажиллах дотоод журам, үйлчилгээний үнийн тариф, гэмт хэргээс урьчилан сэргийлэх анхааруулга бүхий самбар (тамхи татах, согтууруулах ундааны зүйл, мансууруулах бодис хэрэглэхийг хатуу хориглосон тэмдэг, тэмдэглэгээ зэрэг)-ыг үйлчилгээнийг хараадахауйц газар ил байрлуулна.

2.3. Цахим тоглоомын үйлчилгээ үзүүлэх газар нь зуны улиралд (4 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаа) 21.00 цаг, өвлийн улиралд (10 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаа) 19.00 цаг хүртэл үйлчилнэ.

2.4. 12-16 хүртэлх насанд хүрээгүй хүүхдэд зуны улиралд 19 цаг, өвлийн улиралд 16 цаг хүртэл үйлчлэх бөгөөд өдөрт нэг удаа 2 цагаас илүүгүй хугацаагаар үйлчилнэ.

2.5. Цахим тоглоомын газрын үйлчилгээний ажилтан нь мэдээллийн технологийн анхан шатны мэдэгдэхүүнтэй энэ журмын 5.1-д заасан сургалтад хамрагдсан 20-иос дээш насны иргэн байна.

2.6. Ажлын байрны дотоод болон гадна орчинд камерын хяналтын систем суулгасан, энэхүү систем нь 21-ээс дээш хоногийн бичлэгийг хадгална.

2.7. Холбогдох хууль тогтоомжоор хориглосон цахим хуудсыг нээдэггүй тохиргооны программ хангамжийг компьютеруудад зайлшгүй суулгасан байх шаардлагатай.

2.8. Энэхүү журамд заасан чиглэлээр үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээд нь үйлчилгээнийг байгаа хэрэглэгчдийн цахим үнэмлэхээр бүртгэлийг хөтлөх ба эрх бүхий байгууллагын шаардсаны дагуу шаардлагатай статистик мэдээллийг гаргаж өгнө.

3. Бүртгэлийн гэрчилгээ олгох, түр түдгэлзүүлэх, хүчингүй болгох

3.1. Цахим тоглоомын үйлчилгээний бүртгэлийн гэрчилгээг холбогдох эрүүл ахуй, ажлын байрны нөхцөл, галын аюулгүй байдлын дүгнэлт, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо олгоно.

3.2. Бүртгэлийн гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогоомжийн дагуу зохицуулна.

3.3. Энэхүү журмын нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй тохиолдолд бүртгэх байгууллага болон бусад эрх бүхий байгууллага нь зөрчлийг арилгах хүртэл үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг 7-гоос 14 хоног хүртэлх хугацаагаар түр түдгэлзүүлж, энэ талаар бүртгэлийн гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

3.4. Цагдаа, хүүхэд хамгаалах байгууллага, онцгой байдлын болон мэргэжлийн хяналтын байгууллага нь тавьсан шаардлага, мэдэгдлийг удаа дараа биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, гэрчилгээг хүчингүй болгуулах талаар бүртгэлийн гэрчилгээ олгох байгууллагад санал тавьж шийдвэрлүүлнэ.

4. Хориглох зүйлс

4.1. Цахим тоглоомын газар нь дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно:

4.1.1. орон сууцны нэг давхар, зоорини давхарт үйл ажиллагаа явуулах;

4.1.2. хуулиар хориглосон мөрийтэй тоглоом (казино) тоглуулах, түүнийг зохион байгуулах, терроризм, аллага, хучирхийлэл, садар самуун сурталчилсан тоглоом тоглуулах;

4.1.3. энэхүү журамд заасан цахим тоглоомын үйлчилгээг 12 насанд хүрээгүй хүүхдэд үйлчлэх;

4.1.4. бичиг баримт, эд зүйлс барьцаалан иргэдэд үйлчлэх;

4.1.5. согтуурсан болон мансуурсан иргэнд үйлчлэх;

4.1.6. интернэт кафены үйл ажиллагаа явуулж байгаа газарт цахим тоглоом тоглуулах;

4.2. Энэхүү журмын 4.1.2-т заасан хориглосон тоглоомын жагсаалтыг Харилцаа холбооны зохицуулах хороо энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтарч батална.

5. Бусад

5.1. Энэ журамд заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд хүүхдийн эрх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэдтэй харилцах харилцаа болон тоглоомонд донтон тоглох зэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаанд заавал хамрагдсан



байна. Сургалтыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

5.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 411

Улаанбаатар
хот

Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, бүх шатны төсөвт байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаа наарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.САЙХАНБИЛЭГ

Засгийн газрын 2013 оны 411 дүгээр
тогооолын хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ
НИЙТЛЭГ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль (цаашид “хууль” гэх)-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан байгууллага нь (цаашид “байгууллага” гэх), 7 дугаар зүйл, 8.1 дэх хэсэг, 9, 10 дугаар зүйлд заасан мэдээлэл (цаашид “хуульд заасан мэдээлэл” гэх)-ийг цахим хуудсанд оруулж, түгээх, ашиглахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Байгууллага нь хууль болон энэхүү журамд нийцүүлэн өөрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангахаар дотоод журам боловсруулан мөрдөж болно.

2. Журмын нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “биет буюу физик түвшний халдлага” гэж мэдээллийн сан байрлах физик дэд бүтцэд зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг;

2.1.2. “мэдээллийн сан” гэж энэхүү журмаар зохицуулагдах хуульд заасан мэдээллийн нэгдсэн ангилал код, индекс, арга зүй, стандартаар ижилтгэсэн баримт бичгийг шаардлагын дагуу цуглуулж, боловсруулж хадгалсан мэдээлэл, өгөгдлийн бүрдлийг;

2.1.3. “нягтаршуулж байрлуулах” гэж их хэмжээтэй цахим мэдээллийн сангийн багтаамжийг шахаж бага хэмжээтэй болгож байрлуулахыг;

2.1.4. “татаж авах боломжтой” гэж цахим хуудсан дахь мэдээллийг байршил, цаг хугацаа хамаарахгүйгээр тухайн тооцоолуурт (компьютер, хөдөлгөөнт холбооны бусад төхөөрөмжүүд) хадгалахыг;

2.1.5. “устгах” гэж цахим мэдээлэл, өгөгдлийг мэдээллийн сангаас дахин ашиглах боломжгүйгээр арилгахыг;

2.1.6. “цахим мэдээллийн архив бүртгэлийн автоматжуулсан систем” гэж компьютер дээр тусгай зориулалтын бүртгэлийн



программд оруулсан өгөгдөл, мэдээлэлд хандах, засварлах, нэмэх ажиллагааг хялбаршуулсан системийг;

2.1.7. “цахим бичиг баримтын мэдээллийн анхдагч байдал” гэж мэдээллийн санд цахим бичиг баримтыг боловсруулахдаа засвар, өөрчлөлт оруулаагүй анхдагч хувилбарыг;

2.1.8. “цахим хэлбэрт оруулах” гэж цаасан суурьтай мэдээлэл, өгөгдлийг компьютерт хөрвүүлж цахим баримт бичиг үүсгэхийг.

3. Мэдээллийг цахим хуудсанд оруулах, цахим хуудасны мэдээллийн сан үүсгэх, түгээх

3.1. Байгууллага нь цахим хуудасны агуулга, бүтэц, хөгжүүлэлтэд тавигдах шаардлагыг тодорхойлсон MNS 6285:2011 Монгол Улсын стандартыг хангасан албан ёсны цахим хуудсыг үүсгэж, хуульд заасан мэдээллийг ойлгомжтой байдлаар байрлуулж, олон нийтэд түгээнэ.

3.2. Байгууллага нь хуульд заасан мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд тухай бүр байрлуулах үүрэг хүлээнэ.

3.3. Байгууллагын удирдлага нь энэ журмын 3.1 болон 3.2-т заасан цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг оруулах, өөрчлөх, устгах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах асуудлыг хариуцсан ажилтныг (цаашид “эрх бүхий ажилтан” гэх) томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

3.4. Эрх бүхий ажилтан нь албан ёсны эх сурвалжийг үндэслэн хуульд заасан мэдээллийг цахим хэлбэрт оруулан, татаж авах боломжтой, ойлгомжтой байдлаар цахим хуудсанд байрлуулж мэдээллийн сан үүсгэнэ.

3.5. Хуульд заасан мэдээллийг видео, аудио хэлбэрээр цахим хуудсанд байрлуулж болно.

3.6. Хуульд заасан мэдээллийг тухайн цахим хуудсанд ачаалал үүсгэхгүй байдлаар нягтаршуулж байрлуулна.

3.7. Хуульд заасан мэдээллийг цахим хуудас, цахим мэдээллийн самбар болон түүнтэй дүйцэхүйц форматаар хэрэглэгчийн төхөөрөмжид түгээх боломжтой байна.

3.8. Хуульд заасан мэдээллийг шинэчилсэн, өөрчилсөн тохиолдолд өмнөх мэдээллээ цахим хуудасны “архив” хэсэгт хадгалж, энэ тухай мэдээллийг байрлуулна.

3.9. Байгууллага нь хуульд заасан шаардлагатай мэдээллийг англи болон бусад хэл дээр орчуулж цахим хуудсанд байрлуулна.

4. Цахим хуудаснаас мэдээлэл авах, ашиглах

4.1. Байгууллага нь өөрийн цахим хуудас дахь мэдээллийн сангаас хуульд заасан мэдээллийг иргэн, хуулийн этгээд саадгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2. Байгууллагын цахим хуудас дахь мэдээлэл нь албан ёсны байх тул иргэн, хуулийн этгээд нь сургалт, судалгаа, шинжилгээ, мэдээллийн зорилгоор ашиглаж болно.

4.3. Иргэн, хуулийн этгээд тухайн байгууллагын цахим хуудас дахь мэдээллийг ашиглахаа эх үүсвэрийг нь заасан байна.

4.4. Иргэн, хуулийн этгээд нь цахим хуудсанд байрлуулсан мэдээллийг хууль бусаар ашиглахыг хориглоно.

5. Цахим хуудасны мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагааг хангах

5.1. Цахим хуудсанд мэдээлэл байрлуулах, шинэчилэх, өөрчлөх, устгах эрхийг албан ёсны эх сурвалжийг үндэслэн зөвхөн эрх бүхий ажилтан эзэмшинэ.

5.2. Байгууллага нь хуулийн 7.1.5, 9.1.1-9.1.4, 9.2.1-9.2.3-т заасан мэдээллийг хуульд тусгайлан заасан хугацаанд, бусад мэдээллийг тогтмол эсвэл тухай бүр шинэчилж, цахим хуудасны хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

5.3. Байгууллага нь хуульд заасан мэдээллийг цахим хуудаснаас иргэн, хуулийн этгээд ойлгомжтой байдлаар шууд, саадгүй авах боломжийг бүрдүүлж, тасралтгүй хэвийн ажиллуулах нөхцөлийг дэвшилтэт технологитой уялдуулан байнга хөгжүүлнэ.

5.4. Байгууллага нь цахим мэдээллийн архив бүртгэлийг хийж улирал бүр, шаардлагатай бол тухай бүр мэдээллийг татах авч тохиромжтой хэлбэрээр архивлан хадгална.

5.5. Байгууллага нь цахим бичиг баримтын мэдээллийн анхдагч байдлыг хангахын тулд цахим гарын үсгийн тогтолцоог нэвтрүүлнэ.



5.6. Мэдээллийн санд оруулах цахим бичиг баримтыг боловсруулахдаа “Монгол хэлний компьютерийн орчны тогтолцоо”, “Кирилл болон монгол үсгийн нэгдсэн код” MNS 5552:2005 стандартыг мөрдлөг болгоно.

6. Цахим хуудасны мэдээллийн сангийн хадгалалт,
хамгаалалтын найдвартай байдлыг хангах

6.1. Эрх бүхий ажилтан нь цахим хуудасны систем болон цахим мэдээллийн архив бүртгэлийн автоматжуулсан системд нэвтрэх эрхийн нууцлалыг хангах үүрэг хүлээн ажиллана.

6.2. Үндэсний дата төв нь байгууллагын сервер, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг зориулалтын орчинд байршуулан биет буюу физик түвшний халдлагаас хамгаалах, хадгалах, тэдгээрийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах ажлыг тухайн байгууллагатай хийсэн гэрээний дагуу хариуцан ажиллана.

6.3. Байгууллага нь өөрийн цахим хуудсанд техникийн алдаа, аюулгүй байдлын зөрчил, саатал гарсан нөхцөлд даруй шалтгааныг нь тодруулан шаардлагатай гэж үзвэл Тагнуулын ерөнхий газар, Үндэсний дата төвд яаралтай мэдэгдэж хамтран ажиллана.

6.4. Эрх бүхий ажилтан нь албан ёсны эх сурвалжийг үндэслэн мэдээлэл байрлуулах, шинэчилэх, өөрчлөхдөө цахим хуудсанд гэмтэл, саатал учруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.

6.5. Үндэсний дата төв нь аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тухайн байгууллагад өөрийн цахим хуудасны аюулгүй байдлын цоорхойг арилгах, засвар шинэчлэлтийг тогтмол хийх, цахим хуудсыг ажиллуулахтай холбоотой дүрэм журам, стандарт, бусад бодлогын бичиг баримтыг дагаж мөрдөх талаар заавар, зөвлөмж өгч болно.

6.6. Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бүрдүүлэхдээ MNS ISO 17799:2007, MNS ISO/IEC 27001:2009; MNS ISO/IEC 13335-1:2009 стандартуудыг мөрдлөг болгон ажиллана.

7. Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийн
ил тод байдлыг хангах

7.1. Байгууллага нь хуулийн 7, 8, 9, 10 дугаар зүйлд заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг ил тод мэдээлнэ. Үүнд:

7.1.1. Худалдан авалтын төлөвлөгөө;

- 7.1.2. Хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - 7.1.3. Богино болон урт хугацааны зээл, татаас;
 - 7.1.4. Халамжийн зардал;
 - 7.1.5. Дотоод аудитын үнэлгээ;
 - 7.1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон шинээр ажилд орсон албан хаагчийн талаархи мэдээлэл;
 - 7.1.7. Удирдлагуудын гадаад томилолтын талаархи мэдээлэл томилолт бүрээр;
 - 7.1.8. Байгууллагын зардлаар суралцагчдын талаархи мэдээлэл.
8. Хариуцлага, хяналт, хэрэгжилт
- 8.1. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар нь хуулийн 22.1.2-т заасан үүрэг хүлээнэ.
 - 8.2. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар нь энэ журмын 3.2-т заасан нэгдсэн цахим хуудсыг боловсруулах, ашиглалт үйлчилгээг нь хариуцах үүрэг хүлээнэ.
 - 8.3. Энэхүү журмыг зөрчсөнөөс байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдалд хохирол учирсан, ба эмзэг байдал үссэн тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээнлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 412

Улаанбаатар
хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.1-ийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой,



тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мэнхжүүлэх журам"-ын "4.1.2. Багш нарын өдөр-жил бүрийн 2 дугаар сарын эхний Ням гараг" гэснийг "4.1.2. Багш нарын өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 5-ны өдөр" гэж өөрчилсүгэй.

2. Журамд орсон өөрчлөлтийг 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн мөрдэж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 415

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн "Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар" гэснийг "Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар" гэж өөрчилсүгэй.

2. Аймгийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын орон тооны хязгаарыг 15-40 байхаар тогтоосугай.

3. Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын орон тоог үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээтэй нь уялдуулан батлагдсан орон тооны хязгаарт багтаан аймаг бүрт ялгаатай тогтоож, бүтэц, чиг үүргийг батлахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД

Х.БАТТУЛГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 416

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг жил бүрийн улсын төсөв болон гадаадын зээл, тусlamж, төсөл хөтөлбөртэй уялдуулан санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд Н.Удвал нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан Эрүүл мэндийн яаманд ирүүлж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын нэгдсэн тайланг жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Н.Удвалд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Н.УДВАЛ

Засгийн газрын 2013 оны 416 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

“ЭРҮҮЛ НАСЖИЛТ, НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНД”
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

Дэлхий нийт XXI зууныг “Насжилтын зуун” хэмээн нэрлэж, 2002 онд Мадрид хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 156 орны Засгийн газрын тэргүүнүүд оролцсон Ерөнхий чуулганаараа насжилтын асуудлаархи олон улсын төлөвлөгөөг хэлэлцэж, Улс төрийн тунхаглалыг гарган, бус нутаг, гишүүн орнуудад насжилтын асуудлаар өөрийн онцлог



байдлыг тусгасан бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

Манай улсын хувьд УИХ-ын 2004 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, 2004-2015 он хүртэл баримтлах хүн амын хөгжлийн бодлогоо тодорхойлж, хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчинг бүрдүүлэх зорилготойгоор хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 130 дугаар тогтоолоор “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг 1999-2003 онд хэрэгжүүлж хөтөлбөрийн үнэлгээг хийсний үндсэн дээр Засгийн газрын 2003 оны 271 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан 2004-2008 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Олон улсын насжилтын асуудлаархи тунхаглал, төлөвлөгөө (2002 он), Ахмад настны эрхийн тунхаглал (1991 он), Ази, номхон далайн бус нутгийн Насжилтын асуудлаархи Шанхайн стратеги (2002 он) Монгол улсын хүн амын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд урт хугацааны бодлогын чиглэлийг тодорхойлсон “Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаархи үндэсний стратеги”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 156 дугаар тогтоолоор сайшаасан нь нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үйл явцад насжилт, насжилтиг угтах, настны аж байдал, эрүүл мэндийн чиглэлд холбогдох яам, байгууллага, салбар дундын хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах шаардлагатай байгааг тусгасан баримт бичиг болсон юм.

Тус стратеги нь хүн амыг насжилтын үйл явцад бэлтгэх, ахмад настны аж байдлыг сайжруулах талаар 2030 он хүртэл баримтлах урт хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд хүн амын насын бүтцэд гарч буй өөрчлөлт, хандлагад тулгуурлан төлөвлөлтийг ойрын ирээдүйн болон жил бүрээр боловсруулан нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, холбогдох яамд, байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөх замаар хэрэгжүүлэхийг заасан. Цаашид тус стратегийн хэрэгжилтийг хангахад салбар дундын үйл ажиллагааг зохион байгуулахын тулд үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөр, “Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаархи үндэсний стратеги”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Зорилго, зорилт

2.1. Зорилго:

Хүн амын эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжин, настны эрүүл мэнд, халамж, хамгаалал, нийгмийн оролцоог сайжруулан настны амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

2.2. Зорилт

1. Хүн амын эрүүл насжилтыг дэмжих хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх;

2. Настны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх;

3. Настны хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;

4. Эрүүл мэндийн цогц тусlamж, үйлчилгээг настны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх.

Гурав. Баримтлах зарчим

Энэхүү хөтөлбөр нь дараах үндсэн зарчимд тулгуурлана. Үүнд:

3.1. Настны хэрэгцээнд тулгуурлах;

3.2. Настны нэр төрийг өргөх, бие даасан байдал, оролцоог хангах;

3.3. Салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах;

3.4. Эрүүл мэнд, нийгмийн чанартай тусlamж, үйлчилгээг тэгш хүртээх;

3.5. Хот, хөдөөгийн онцлог байдлыг харгалзах;

3.6. Жендерийн тэгш байдлыг хангах.

Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

I үе шат 2014-2017 он

II үе шат 2018-2020 он



Тав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт 1. Хүн амын эрүүл насжилтыг дэмжих хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ:

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах шийдвэр гаргагчдын түвшинд салбар дундын оролцоог хангасан дэд зөвлөлийг Эрүүл мэндийн дэд сайдаар удирдуулан байгуулах;

2. Дэд зөвлөлийн ажлын албаны үүргийг Геронтологийн үндэсний төв гүйцэтгэх;

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийн дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;

4. Эрүүл насжилт, настны эрүүл мэндтэй холбоотой хууль эрхзүйн орчны үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх;

5. Настанд ээлтэй байгууллага, аж ахуйн нэгж, баг, хороо, сум, дүүргийг шалгаруулах удирдамжийг олон улсын жишиг үзүүлэлтийн дагуу боловсруулж, шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

6. Монгол хүний насжилт, настны эрүүл мэндийн талаархи эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, мэдээллийн нэгдсэн сан бий болгох;

7. Хүн амын эрүүл насжилт, настны эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах.

Хүрэх үр дүн:

1. Хүн амын эрүүл насжилтыг дэмжих салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх эрх зүйн орчин бүрдэн, төрийн бодлого шийдвэрийг үе шаттайгаар хэрэгжүүлснээр хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ.

2. Нийгмийн зүгээс настанд хандах эерэг хандлага бэхжинэ.

3. Настны хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралын оролцоо сайжирсан байна.

4. Хүн амын эрүүл насжилтыг дэмжих, настанд ээлтэй дүүрэг, сум, хороо, баг, аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байр, зам, талбай бий болно.

5. Хүн амыг эрүүл насжилтын талаар нотолгоонд тулгуурласан мэдээллээр хангах, судалгаа, сургалт, мэдээллийн тогтолцоо бүрдсэн байна.

Зорилт 2. Настны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ:

1. Настанд зөв хооллолт, дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх үйл ажиллагааг дэмжих мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

2. Осол, гэмтлээс сэргийлэх сургалт, сурталчилгааг зорилтот бүлгэд зохион байгуулах;

3. Архи, тамхины хор уршигийн тухай, архи тамхинаас гарсан сайн туршлагын талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

4. Орон нутагт настанд зориулсан явуулын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах;

5. Настны сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг дэмжих, олон нийт, байгууллага, хамт олонд тулгуурласан үйл ажиллагааг дэмжин өргөжүүлэх;

6. Настанд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, олон эмийн хэрэглээг бууруулах сургалт, сурталчилгааг өргөжүүлэх.

Хүрэх үр дүн:

1. Эрүүл зан үйл, амьдралын хэв маягийг хэвшүүлж, осол, гэмтэлд өртөх эрсдэлийг бууруулж, Монгол хүний эрүүл, урт наслалтыг дэмжсэнээр дундаж нас уртасна.

2. Хүн амын хорт зуршлын хэрэглээ буурна.



3. Эмийн зохистой хэрэглээний түвшин нэмэгдэнэ.

Зорилт 3. Настны хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ:

1. Настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

2. Тэтгэвэрт гаражын өмнө болон гарсны дараах сургалтын төв, дамжаа, ангийг үүсгэн байгуулж, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах;

3. Настны сайн туршлагыг судлах, дэмжих, нэвтрүүлэх;

4. Настны сайн дурын болон үүсгэл санаачлагын байгууллага, настанд үйлчлэх төв, настны хөгжлийн төв, клуб зэрэг төрөл бурийн байгууллагуудын талаар олон улсын туршлагыг судалж, өөрийн оронд боломжит хэлбэрүүдийг нутагшуулах;

5. Настанд зориулсан асрамжийн үйлчилгээг өргөжүүлэх;

6. Хүний хөгжлийн төвүүдийг байгуулж, бүтэц, зохион байгуулалтад эрүүл насжилт, настны эрүүл мэндийг дэмжих нэгж, хэсгийг оруулах.

Хүрэх үр дүн:

1. Тэтгэвэрт гаражын өмнө болон гарсны дараа настан нь мэргэжлийн чиг хандлага бүхий төрөл бурийн ажлын байранд ажиллах мэдлэг, чадварыг эзэмших сургалтанд хамрагдсанаар хөдөлмөр эрхлэх боломжтой болж, хөдөлмөр эрхлэлт дэмжигдэн тэдний орлого, нийгмийн оролцоо дээшилнэ.

2. Настанд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тоо болон настанд үзүүлэх үйлчилгээний төрөл нэмэгдэнэ.

Зорилт 4. Эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг настны хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ:

1. Улсын хэмжээнд настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын нэр, төрлийг өргөжүүлж, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох;

2. Геронтологи, гериатрийн салбар өндөр хөгжсөн орны туршлагыг судалж, эх орондоо нутагшуулах;

3. Үндэсний түвшинд настны эрүүл мэндийн чиглэлээр лавлагаа тусламж үзүүлэх Геронтологийн үндэсний төвийн шинэ барилгыг ашиглалтад оруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган ажиллуулах;

4. Геронтологи, гериатрийн мэргэжлээр хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх;

5. Настанд гэрээр үзүүлэх олон мэргэжлийн багийн тусламжийн хамрах хүрээг өргөжүүлэх, чанарыг сайжруулах.

Хүрэх үр дүн:

1. Улсын хэмжээнд геронтологи, гериатрийн мэргэжлийн бие даасан байдал хангагдаж, геронтологи, гериатрийн салбар өндөр хөгжсөн орны туршлагаас судалж, Монгол Улсдаа нутагшуулан хэрэгжүүлснээр настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, настан тусламж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй хүртэнэ.

2. Настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, шаардлагагүй эмнэлэгт хэвтэлт цөөрч, эмнэлгийн ачаалал буурна.

Зургаа. Санхүүжилт

Улсын төсөв, Олон улсын байгууллагын хандив тусламж, Эрүүл мэндийг дэмжих сангийн төсөвт тусган санхүүжүүлнэ.





Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

| № | Шалгуур үзүүлэлт | Өнөөгийн түвшин | 2017 онд хүрэх түвшин |
|--|---|---|--|
| Зорилт 1. Хүн амын эрүүл наскилтыг дэмжих нийгэм, эдийн засгийн эзлтэй орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд | | | |
| 1. | Настанд эзлтэй байгууллага, аж ахуйн нэгж, хороо, баг, сум, дүүргийн тоо | Настанд эзлтэй байгууллага, аж ахуйн нэгж, хороо, баг, сум, дүүрэг байхгүй байна. | Настанд эзлтэй байгууллага, аж ахуйн нэгж, хороо, баг, сум, дүүргийг бий болгосон байна. |
| 2. | Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилтнуудынхаа эрүүл наскилтыг дэмжих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах | Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хувьд харилцан адилгүй байна. | Албан байгууллага, аж ахуйн нэгж эрүүл наскилтыг дэмжих ажлын байрыг бий болгож, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг болно. |



| Зорилт 2. Наастны эрүүл мэндийг дэмжих, өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд | | | |
|---|---|--|--|
| 1. | Хоол тэжээлийн дуталд орхуулсан сургалтадын хувь | 31 хувь | 20 хүртэл хувиар бууруулна. |
| 2. | Хоол тэжээлийн дуталтай наастны хувь | 3.1 хувь | 30 хүртэл хувиар бууруулна. |
| 3. | Дасгал хөдөлгөөний хомсдолтой буюу жингийн илүүдэл, таргалалттай наастны хувь | 17.4 хувь | 30 хүртэл хувиар бууруулна. |
| 4. | Танин мэдэхүйн чадварын бууралт | Танин мэдэхүйн чадварын бууралт 16.1 хувь | Танин мэдэхүйн чадварын бууралтыг 20 хүртэл хувь багасгана |
| Зорилт 3. Наастны хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралд оролцоог дээшлүүлэх зорилтын хүрээнд | | | |
| 1. | Наастны хөдөлмөр эрхэмлтийн хувь | 8.3 хувь | 15 хувьд хүргэх |
| 2. | Тэтгэвэрт гарахын өмнөх, гарсны дараах сургалтын хөтөлбөр | Байхгүй | 3 хөтөлбөр |
| 3. | Тэтгэвэрт гарах настнуудад зориулсан сургалтын төв/ Third age institute/ | Байхгүй | 1 |
| Зорилт 4. Эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг наастны хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд | | | |
| 1. | Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтний тоо | Мэргэшсэн гериатрийн эмч б ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 2-р шатлалд насны сувилахуйгаар мэргэшсэн сувилагч одоогоор байхгүй. | Мэргэшсэн гериатрийн эмчийн тоог 15-д хүргэх Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 2-р шатлалд настны сувилахуйгаар мэргэшсэн ажиллавал зохих сувилагчийн тоог 50 хувьд хүргэх |
| 2. | Эрүүл мэндийн байгууллага дахь Гериатрийн тусламж үзүүлэх нэгжийн тоо | 1 төв 16 кабинет | 1 төв 21-ээс дээш кабинет |
| 3. | Гэрийн тусламж авсан наастны тоо | 1.4 хувь | 20 хувь хүртэл нэмэгдүүлэх |

Хүн амын нас хүйсийн сувага, 2010-2040 он





Монгол Улсын хүн амын тоо, хэтийн төлөв байдал

| Нас | Улсын дүн | | 2015 | | 2020 | | “2Б” хувилбар | |
|-------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|
| | 2010 | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Бүгд | Эрэгтэй |
| Бүгд | 2 739 001 | 1 356 157 | 1 382 844 | 2 983 508 | 1 471 677 | 1 511 831 | 3 216 543 | 1 580 245 |
| 0-4 | 291 427 | 147 978 | 143 449 | 317 665 | 161 090 | 156 575 | 312 128 | 158 264 |
| 5-9 | 218 130 | 111 071 | 107 059 | 290 132 | 147 098 | 143 034 | 316 561 | 160 291 |
| 10-14 | 239 025 | 121 136 | 117 889 | 217 790 | 110 820 | 106 970 | 289 745 | 146 800 |
| 15-19 | 265 300 | 134 211 | 131 089 | 238 537 | 120 760 | 117 777 | 217 405 | 110 511 |
| 20-24 | 310 802 | 156 738 | 154 064 | 264 292 | 133 408 | 130 884 | 237 775 | 120 132 |
| 25-29 | 267 183 | 133 882 | 133 301 | 308 937 | 155 240 | 153 697 | 262 983 | 132 323 |
| 30-34 | 238 013 | 118 794 | 119 219 | 264 983 | 132 121 | 132 862 | 306 860 | 153 532 |
| 35-39 | 214 494 | 106 008 | 108 486 | 235 244 | 116 599 | 118 645 | 262 488 | 130 101 |
| 40-44 | 186 128 | 91 130 | 94 998 | 210 802 | 103 153 | 107 649 | 231 894 | 113 949 |
| 45-49 | 161 997 | 78 653 | 83 344 | 181 436 | 87 626 | 93 810 | 206 288 | 99 714 |
| 50-54 | 123 257 | 58 416 | 64 841 | 155 822 | 74 195 | 81 627 | 175 416 | 83 183 |
| 55-59 | 72 285 | 33 462 | 38 823 | 116 303 | 53 610 | 62 693 | 147 944 | 68 571 |
| 60-64 | 49 473 | 22 096 | 27 377 | 66 399 | 29 497 | 36 812 | 107 546 | 47 614 |
| 65-69 | 38 176 | 17 218 | 20 958 | 43 493 | 18 357 | 25 136 | 58 960 | 24 747 |
| 70-74 | 29 258 | 13 033 | 16 225 | 31 597 | 13 262 | 18 335 | 36 601 | 14 266 |
| 75-79 | 18 564 | 7 221 | 11 343 | 22 347 | 9 081 | 13 266 | 24 590 | 9 302 |
| 80+ | 15 489 | 5 110 | 10 379 | 17 819 | 5 760 | 12 059 | 21 359 | 6 945 |

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 1. Амьдралын мөчлөг, насны ангилал** -Хүн судлаачид, хүн ам зүйн судлаачид, хүн амын бүртгэл, тооллого хариуцсан ажилтнууд, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, эдийн засагчид гэх мэт олон төрөл чиглэлийн ажил мэргэжлийн хүмүүс хүний амьдралыг янз бүрийн өнцгөөс нь авч үзэн, тодорхой үе шат болгон ангилсан ангилал
- 2. Настан** -55 ба түүнээс дээш насны эмэгтэй, 60 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийг оруулан тооцно
- 3. Хөгшрөх насны үе** -эмэгтэй 55-84 нас,
эрэгтэй 60-84 нас
- 4. Хижээл нас** -эмэгтэй 45-54 нас,
эрэгтэй 50-59 нас
- 5. Ахимаг нас** -эмэгтэй 55-64 нас,
эрэгтэй 60-64 нас
- 6. Ахмад нас** -65-74 нас (хүйсний ялгаагүй)
- 7. Өтөл нас** -75-84 нас (хүйсний ялгаагүй)
- 8. Өндөр нас** -85 түүнээс дээш нас
(хүйсний ялгаагүй)



Засгийн газрын 2013 оны 416 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**“ЭРҮҮЛ НАСЖИЛТ, НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Хүрэх үр дүн | Шалгуур Узувалт | Харцуу байгууллага | Хамтран ажиллах байгууллага | Зардал төсөвийн үүл ажиллагаа | Төсөв (сая төгрөгөөр) |
|---|--|-----------|---|---|---|--|---------------------------------------|--------------------------|
| Зорилт 1. Хүн амын зорилгыг дээвжлийг хульь эрх зүй, нийтгэм, эдийн засгийн таатай орчинг буруулжээ | | | | | | | | |
| 1.1 | Хөгөөнберийт хэрэгжүүлэх сандбэр дундан дэд зөвлөлийг байгуулж, зөвлөлийн ажлын анданы Уургийг геронтологийн үндэсний төв гүйцэтэн экилэх | 2014-2020 | Хөгөөнберийт хэрэгжүүлэх шардлагатай нутгийн уидэрдэгчийн бүтэй болсон байна. | Хөгөөнберийг хэрэгжүүлэх шардлагатай зөвлөгөөн тогтолц ажилладаг боловсрон байна | Эмч, Хахижхя | ХЯ, ЗЭХЯ, СЯ, ХЭДШУЯ, БХЯ | Улаанбаатар хотод ажилласж завслол | 6.3 |
| 1.2 | Хөгөөнберийт хэрэгжүүлэх орон нүүтийн дэд хөгөөнберийт боловсруулж хэрэгжүүлэх | 2014-2020 | Орон нутагт хөгөөнбер хэрэгжих эрх зүйн орчин бүрдэнэ. | Хөгөөнбер боловсруулсан байна. Хөгөөнберийн хэрэгжилтийн хувь | Аймаг, Нийслэлийн Засаг дараа | Нүүтийн өөрөө үеидэх байгууллага | 21 аймаг, 9 дүүргэг хэрэгжүүлэх. | Орон нүүтийн төсөв |
| 1.3 | Эрүүл насхийт, настны эрүүл мэндээх хөлбөгдох хульь эрхэйн орчны судалгаа хийж, учраалээ хийж зөвлөлийг боловсруулж, хүүхд намзгийт, аяртгүйт оруутах саналыг З-ын хиргэдаанд хэрэгжүүлэх (настадаа гарзэр зуулж тусимж үүлчилгэнээ зардлыг хамжийкаас санхүүжүүлж, хульь эх зүйн орчны буруулжээ. Настнууд бүхий, спорти, чиррагжүүлэлт; фитнес клибуздуудээр хөгөөнчтэй чөв, двагталаар үйнчлүүлжээ) | 2015 | Холбогдох хульь нахцэйт, еөрчилжт оруутах саналыг боловсруулж хүрүүлж байна. | Үнэлгээний такланж, зөвлөж, Нэнэлж өөрөө үеидэх байгууллага | Эмч, ГҮТ ХЯ, ХАХЖХЯ, ХЯ, ЗЭХЯ, СЯ, Нүүтийн төсөл | 2014 онд 4 аймаг, 16 сум, 4 дүүргэг суудалгаа хийх | 2014 онд 4 аймаг, 16 | 28.3 |



| | | | | | | |
|-----|---|-----------|---|--|--|--|
| 1.4 | Настанд зэлтгэй байгууллага, аж ахуйн нэг, баг, хороо, сум, дүүрэг шалгаруулж үзүүлэх болсовруулж шалгаруулж үзүүлэх болсовруулж зохион байгуулж | 2015-2020 | -Настанд зэлтгэй байгууллага, хамт олон, сиймыг шалгаруулж үзүүлэх болсовруулж зохион байгуулж | -Боловсруулсан удирдаамж -Хийсан ахуйн тоо, цэр хүрээ -Хэвлэсэн таалагтгийн тоо -Шалгарсан байгууллага, аж ахуйн нааж, хороо, сум, дүүрэгийн тоо | Дэд зөвлөлт Яамд, нутгийн захижаны боловсруулах 5 хувийн бурялдахнуутгай эжлийн хосг байгуулж , удирдахийн дагуу Улз ажиллагаага явуулах, тайллан байгууллага, Олон улсын байгууллага аж ахуйн нааж, хүчээгээ хийж, шалгаруулж үзүүлэх болсовруулж зохион байгуулж | Жил болгон удирдаамж боловсруулах 5 хувийн бурялдахнуутгай эжлийн хосг байгуулж , удирдахийн дагуу Улз ажиллагаага явуулах, тайллан байгууллага, Олон улсын байгууллага аж ахуйн нааж, хүчээгээ хийж, шалгаруулж үзүүлэх болсовруулж зохион байгуулж |
| 1.5 | Настанаа хүндэтгэн дээдрэгхэн зан Ули, соён, уланихийлан хадгалах, нийтийн зөврөө хадгалах, дээжийн хадзээн, сургалт, сургалтчилгаат явуулах төгөөвийн нэвтрүүлэгтэй болж тогтолцоот үзүүлэлтэй явуулах | 2015-2020 | -Настанд үндэслэх нийтийн хадгалах, хандлагын салжираа. | -МСС-ны тоо -Судалжны тайлбан -Үзвэрүүлийн тоо -Үзэгчдийн тоо | ЭМЯ, ГГТ БИУЧ, ЭМХТ, НЭМУТ, АЛБАН байгууллага, аж ахуйн нэжкууд, ТББ | Жил бир -сургалтын гарын авлагын балтгах -сургалтын балтгах 2 адьрийн сургалтыг 4 бусад 1, хотод 1, нийт 5 удаа тус бүр 60 хувид -сургалчилгаас олон нийтийн радио төслийзээр хилд, 3 удаа хөтөлбөрийн хугацаанд явуулна. |
| 1.6 | Монгол хүний нааскылтын тапархын эрээм шинжилгээ, судалгааны эжлийг олон улсын жишгийн хүчин аргалцаар явуулж өргөжүүлж, мэдээний сан бий болгох | 2014-2017 | Бодлого боловсруулж, шийдвэр гаргагчдыг шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэлээр тасралтгийн хантгаа. | -Мэдээллийн сантай болсон баана, Хийдсэн эрдэм шинжилгээ судалгааны тоо | ЭМДС ЭМЯ, ДЭМБ, ГГТ | Хөтөлбөрийн хугацаанд 4 төрлийн улсын хамжээний судалгааг жил бир явуулж, мэдээний сан бий болгох |



| | | | | | | | | |
|-----|---|-----------|---|--|-----------------|---|---|-------|
| 1.7 | Байгууллага, эж ахуйн нэрж бүр ажилтны хаяа зөвүүл нэсжилтийг дамжих (ажлын байрны дэслэгт хийх, зөв хоолгох, спорт, чигрэгүүлэлийн танхимаар үзүүлчилгэх боломж нийтийн хангах, урьдчилсан сэрийлэх узлагт жил бүр оруулааг, эрүүлжилүүлэх үүд ажиллагааг зөсжин байгуулах, амраалт, сувилын газар амраах г.и) үйл ажиллагчдын зарыг жил бүрний тасвиреэ тусган санхүүгүүз | 2015-2020 | Албан Байгууллага, аж ахуйн нэрж бүр ажилтнуудынхаа эрүүл мэндийн анхдартан тавих хэрэгжүүлэгийн тоноглолтой болгоог хэрэгжүүлжинээр хий амьн эрүүл насжилтийн эмэгдээнэ. | -Хөрөгжүүлэсэн тоо -Хөрөгжүүлэсэн тоо | ЭМЯ, СЯ | Бүх яамд, байгууллага, аж ахуйн нэжийн тайллан хүлээж авч, дунжж хангийт тэвээж ажиллах | Үндэсний зөвлөл тайллан хүлээж авч, дунжж хангийт тэвээж ажиллах | |
| 1.8 | Хүчин амьн эрүүл насжилтийт, настны эрүүл мэндийн дэлжих эрхийн тиймийн орцлоо сэйжирна. | 2015-2020 | Эрүүл насжилтийт, настны эрүүл мэндийн дэлжих нийтийн орцлоо сэйжирна. | -Аच хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайллан, тоо -Дэмжжигтэй васан байгууллагын тоо | ХАХНХЯ, ЭМЯ | ХҮБГ ГҮТ, НДЕГ, СЗҮТ, байгууллагын орцлоо сэйжирна. | ТӨРИЙН ТББ, хувийн хэвшлийн байгууллагыг судлах, үнэлгээ хийх (7 хажийн түрийн жилд 1 удаа 10 хийний бүрэлдэхүүнтэй баг ажиллана) | |
| 2.1 | Настайд зөв хооплотыг дэмжих мэдээлэл, сургалт, сургалчилгааг зөхийн байгуулах | 2015-2020 | Настайд зөв хооплотыг дэмжих, зөхийн дэж, холтой тэжээлэлээс шалтгаалан усныг өвлийнин тоо буурна, хүчин амьн эрүүл мэнд сайжирна. | -Зөхийн байгуулсан үйл ажиллагааны тоо, хамраадсан настын тоо | ЭМЯ, НЭМҮТ, ГҮТ | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага, нийтийн өөрөө УИДРАХ байгууллага | -Гарын авлагыг (жилд 1 кино, 10 зөвлөмж, 2 ном), боловсролыг сургалт багш байгаль эзлэхийн тайллан хийх (улирал тутамд 1 нийр мэдээлэлтэй гардаж сонина, жилд 3 удаа TV-эрээ) ЗНАХУУ ажлыг хөгөөнөөрөйн хугацаанд жил бүр хийнэ | 178.6 |



| | | | | | | | | |
|-----|--|-----------|---|--|--------------|---|--|---------------------------|
| 2.2 | Хүн амын идэвхтэй дасгал ходоо төвийн тогтол хичээллэх үүл ажиллагааг дэмжих, тамцан, уралдаан зохион байгуулах, сургалтыг тогтол явлуулж | 2014-2020 | Иргэд эрэгтэй амьдралын хувьшийг баримталаад болно. Хөөчлөгчийн үсүүсж шалтгаалан буурияа. Хүн амын эрүүл мэнд сийжирна. | -МСС-ны тоо, чандар | ССАЖЯ | ЭМЯ, ГҮТ НЭМУТ, нутгийн өөрөө удирдах байгууллага, Альмар, НИЙСЛЭЛИЙН засаг дарга | Жил бүр -дасгал хөөчлөгчийн 2 жор шинээр боловоруулж (2 жор хийж 10000 хувь хэвлэж, орон нутгаар дэлгэрүүлж, 10 зөвлөлж) | 78.9 |
| 2.3 | Ахуйн болон зам тээврийн осол, гэмтээс соргийзхөх сургалт, сургалчилгааг зорилтой бүтлийнхэнд зохион байгуулж | 2015-2020 | Ахуйн болон зам тээврийн осол, гэмтээд өөртэй эрдээл бүрснаар тэдгэрээс шалтгаалах нас баралт, овчилгийн тоо буурна. | -МСС-ны тоо, чандар зөвлөлж номны тоо | ЭМЯ, ЭМДС | БХБЯ, ЗТИЯ, НЭМУТ, ГҮГССЭТ, ЭМХТ, ЗЦГ, НИЙТИЙН өөрөө чандарах боловоруулж (1 ном) болослуулж 2 -Сургалчилгааг хийж (улирал тутамд 1 нүүр мэдээллийг сонинд гаргах, жилд 3 Удаа ТҮ-эрд) | Хөгжлийн хугацаанд хөгжлийн дэвтахжигаар -гарын авлагыг (1 кино, 5 зөвлөлж 2 ном) болослуулж 2 -Сургалчилгааг хийж (улирал тутамд 1 нүүр мэдээллийг сонинд гаргах, жилд 3 Удаа ТҮ-эрд) | 72.2 |
| 2.4 | Осол, гэмтээс соргийзх аюулгүй гаавад ба дотоод орчны бурдупух улж ажиллагаат байгууллага, нэгж, шатгат бүрт зохион байгуулж | 2014-2020 | Настанд эзлэгэй орчин буджэж настны ичнэ, бэртэл, гэмтээс зарчилсан урьдчилсан сарчилсан. | -Настанд эзлэгэй орчин буджэж настны ичнэ, бэртэл, гэмтээс зарчилсан урьдчилсан сарчилсан. | БХБЯ | ЭМЯ, ГҮТ, НИЙТИЙН өөрөө чандарах байгууллага, Альмар, НИЙСЛЭЛИЙН засаг дарга, эж аюун нэгж, байгууллага | Зээлэй орчин байдлын стандарти, удирдамжийг яамд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хийж, үнэлгээ хийж. | Одоон нүүгийн төсөв |



| | | | | | | | | |
|-----|---|-----------|--|--|----------------|--|---|---|
| 2.5 | Орон нутгийн настайд зорилуулсан явууллын сургалт, сургалчилгаа зөхийн байгууллах, үйлчилган саргийлэх узлаг зөхийн байгууллах | 2014-2020 | Орон нутгийн настайд хэрхэг эрчүүг мэндэлийн Тусгамжийн хурзамж сэйжирүүр, явын эрт иргүүлэг намзандын, настийн эрчүүг мэндэлийн боловсрол дэшилнэ. | Зохион байгуулсан явууллын сургалт сургалчилгааны тоо, явууллын Узлаг, шинийгээнд хамраадсан хүний тоо | ЭМЯ, ЭМДС | ГҮТ, бүх шатны эрүүл мэндэлийн байгууллага, ХААНХЯ, Нийтийн төсөв | Явууллын сургалт, сургалчилгаа, саргийтэх узлагийг алслагдсан бай, хородын жилд 2 удаа 6-10 хүний бүрэлдэхүүн тайзэрх зөхийн байгууллах | Орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр |
| 2.6 | Настны сэргээлийн эзувул мэндийн байдлыг давжих олон нийт, хамт олондаа түргүүр асуан сургалт, видео хийзгэл, уулзант зөхийн байгууллах, гарын авлагыг зөвлөж боловсруулах, | 2015-2020 | Настны сэргээлийн эзувул мэндийн давжих сургалт, сургалтилгэг чийт хүн яягуулах настны сэргээлийн эзувул мэндийн бийцэл, өвччелүү буруна. | -Нийтэд хамт олонд түргүүрасан үйл ажиллагааны тоо, герэл, хамраадсан настны тоо | ЭМЯ, ГҮТ | СЭМУТ, НЭМҮТ, ХААНХЯ, бүх шатны эрүүл мэндэлийн байгууллага, Нийтийн төсөв | Жил бүр тогтолц -гавын авлагы (1 кино, 10 зөвлөмж, 2 нох) боловсруулах сургалт зөхийн байгууллах, үйлчилгээнд хамраадсан настайшний засаг дараа | Жил бүр тогтолц -гавын авлагы (1 кино, 10 зөвлөмж, 2 нох) боловсруулах сургалт зөхийн байгууллах, үйлчилгээнд хамраадсан настайшний засаг дараа |
| 2.7 | Настны сэргээлийн эзувул түргэлт, алдас, танцавардлас саргийлэх сургалт, сургалчилгааг явууллах | 2015-2020 | Настан сэргээлийн эзувул түргэлт, алдас, танцавардлас саргийлэх агаа хамжээг авч хэрэгжүүлэх мэдэгтэй болно. Настны сэргээлийн эзувул мэнд сэйжирна. | -Сургалт, сургалчилгааны тоо -Хамрагдсан хүний тоо | ЭМЯ, ЭМДС, ГҮТ | СЭМУТ, бүх шатны эрүүл мэндэлийн байгууллага, Нийтийн төсөв | Хөгөлбөрийн хулааанд жил болгон -гавын авлагы (кино, зөвлөмж, Ном), боловсруулах сургалт байгууллага, Альмай, Нийслэлийн засаг дараа | Хөгөлбөрийн хулааанд жил болгон -гавын авлагы (кино, зөвлөмж, Ном), боловсруулах сургалт байгууллах, Альмай, Нийслэлийн засаг дараа |

58.2

| | | | | | | | | |
|-----|---|-----------|--|---|--------|--|--|--|
| 2.8 | Настайд эмийн зохистой хэрэглээ, олон эмийн хэрэглээ буруулах сургалт, сургалчилгааг өргөхүүлэх | 2015-2020 | Настны эмийн зөв, зохицтой хэрэглээ төлөвшине. | -Гаргасан гарын автайн тоо -Сургалт, сургалчилгааны тоо -Хамрагдсан хүний тоо | ЭМЯГҮТ | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | -Гарын авлагыг (жил болгон 1 кино, 2 зөвлөж, 1 ном) боловсруулах -Сургалчилгааны байгаль эжил болгон 4 бүс, УБ хотод 5 удаа тус бүр 60 хунд) | -Гарын авлагыг (жил болгон 1 кино, 2 зөвлөж, 1 ном) боловсруулах -Сургалчилгааны байгаль эжил болгон 4 бүс, УБ хотод 5 удаа тус бүр 60 хунд) |
| 2.9 | Настны ЦГ агаарын аюултай узэглэл (агаарын температурын орцом өөрчлөлийт, хүчтэй аадар бороо, цэс), агаарын бодилгоос урьжсан антарийн туслах агаарын ажлыг опхос сургалт, сургалчилгааг зохион байгуулах | 2015-2020 | Настнууд байгалийн болон цаг агаарын өөрчлөлийн УЧ юврее болон бусад туслах мэдлэг чадвартай болсон байна. | Зохион байгуулсан сургалт, боловсрогдсон гарын авлагын тоо | БОНХЯ | ЭМФ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | Жил бүр тогтолц нийт хүн амд чиглэсэн сургалчилгаа -2 удаа настанд зоруулсан гарын авлагыг (2 кино, 5 төхлийн зөвлөж, 2 гарын авлагы) | Жил бүр тогтолц нийт хүн амд чиглэсэн сургалчилгаа -2 удаа настанд зоруулсан гарын авлагыг (2 кино, 5 төхлийн зөвлөж, 2 гарын авлагы) |



| | | | | | | |
|-----------|--|-----------|---|---|--|---|
| | | | | | | |
| Зорилт 3. | Настын хөгжлийн, хамгаалаал, нийгмийн амьдралд оролцоог дээшшуүлэх | | | | | |
| 3.1 | Настын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр бодлогын санал, зөвлөхөө, болсворуулах, зорилтад булгыд, чиглэсэн үйл ажиллагаат зохион байгуулах (Ботинистосон цагаан, эзлэжээр, улираар, гэрээгээр ажиллах оног тарлийн хөгжлийн бий болгох, судалгааг бий болгох, ХАА, газар таривалан, үүлчлэгчийн салбарыг ажлын бакрын нализдүүлэх, хөшүүрэй, механизмын бий болгох) | 2015-2020 | Наастны хөдөлмөр эрхлэлтийн эрхлэлтийн баглагдсан санал, -настын хөдөлмөр эрхлэлтийн хувь | ХЯ | ХАХНХЯ, ГҮТ, Орон нутгийн өврийн диддаах байгууллага | Хөгжлийн худалдаанд жил болгон хүргэхийн хөдөлмөр эрхлэлтийг дэвшиж хийж, настын хөдөлмөр эзлэжээр ажлын хөгжлийн санал, зөвлөхөө, болсворуулж, бодлогын холбогдох эрх бүхий байгууллагасар шийдвэрлүүлэх |
| 3.2 | Наастныа мэргэжлийн зөвлөгөөг яхь эрхийн зөвлөгөө, настныа хөдөлмөр эрхлэхдээ зуучлах үүлчлэгчийг бий болгох | 2014-2020 | Наастныудын мэдэгдэл Түршлагаяа бусадтай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөшүүрэлт болно. | ХЯ | ХАХНХЯ | 21 аймаг, нийслэлд настнуудын мэргэжлийн зөвлөгөөг яхь эрхийн зөвлөгөөг яхь эзлэх, зуучлах, үзүүлэгч, үйнчлупачийн тоо |
| 3.3 | Тэтгэвэрт гарахын өмчөх настныа зорилсан албан ба албан бус сургалтын хөгжлийг болсворуулах сурган багш нарын балгатэх, мэдэг олгох сургалтыг яймаг дүүрэг, сумын Насан түрийн боловсролын төвийн нэржийт түүштэн явуулах | 2015-2020 | Сургалтын хөгжлийг боловсруулж сургач башын балгассан байна. Тэтгэвэрт гарахын өмчөх настныа зорилсан сурган багш нарын балгатэх, мэдэг олгох сургалтыг яймаг дүүрэг, сумын Насан түрийн боловсролын төвийн нэржийт түүштэн явуулах | -Болсворуулсан хөгжлийн тоо -Балгассан сургач багшин тоо -Сүргэлтанд хамрагдсан иргэний тоо | БИУЯ, ЭМЯ | ЭМХТ, ГҮТ |
| 3.4 | Тэтгэвэрт гарахын өмчөх болон гарсны дараах сургалтын төв, дамжуулж, сайн дүрнэн клубуудийг амжийн, дураг-сумын насан түрийн боловсролын төвийн нэржийт түүштэн явуулах | 2015-2020 | Наастны дараах сургалтын төв, дамжуулж, сайн дүрнэн клубуудийг амжийн, дураг-сумын насан түрийн боловсролын төвийн нэржийт түүштэн явуулах | -Байгуулд тэтгэварт гарсны дараах амьдралыга артнаас төлөвлөх, зуруу Известийн амьдралыг сурвь төвлөгднө. | БИУЯ, ЭМЯ, ДАМЖААН, АНГИЙН ТОО | ЗЭХЯ, ГҮТ, ХАХНХЯ |
| | | | | | | |

| | | | | | | | | | |
|-----|--|-----------|--|---|----------------------|---|--|---|--|
| 3.5 | Тэгтаварт гэрэвчнүүдийн насныхан болон настайць зориулсан насан туршийн боловсрол олгох сургалтыг багш нарьн каргэхил дэвшүүгээх сургалтыг тусган туршийн боловсролын үндэсний болон амжат, дүргүйн төвчүүзэр дэвжүүлэх зохион байгуулах | 2015-2020 | Хөтөлбөрүүлийн дагуу сургалтыг явуулах саашаалын болосон хүнээр хангажж сургалтуудыг зохион байгуулаха. | -Багтэдэсэн боловсон хүнний тоо -Зохион байгуулсан сургалтын тоо | БШУЯ, ЭМЯ | ГҮТ, нутгийн өөрөө бодлогоор байгууллага, Аймаг, Нийслэлийн засаг дарга | Сургалтыг болж болгах сургалтыг УБ хот, 4 бусад жилд 1/дээ тус бүр 60 хүнд зохион байгуулаха. (жил богтол) | 70.2 | |
| 3.6 | Настны сайн туршилтыг судрах, дэлжих, сургалтын төвчүүзэр дэвжүүлэх | 2014-2016 | Настнуудын сайн туршилтыг судрах түшлэх яй дэлжих сургалчилснаар тэдний нийтийн орцоюу, амдралын чанар дээшилтина. | Сайн туршилтыг тоо | ЭМЯ, ГҮТ, ЭМДС | ХЯ ХАХНХЯ | Настнуудын сайн туршилтын галигийн хүзүүн авах, олон мэдээлэл жилд нэг удаас ахлаадын баярлаар сургалтын хийлийн тусл тасралттай зувлух | 10.3 | |
| 3.7 | Настанд сургалтын болон усгэл саанаалтын байгуулала, настанд эйчилж төв настны хөгжлийн төв, клуб, одор өнхүүлэх бүтэг, сагрээн засалтын төв зэрэг төрөл түрийн байгуулалтуудын тапар опон үсүүн туршилтыг судлах, өөрийн оронд боломжит холбогдуудыг нутгийншүүлах | 2014-2020 | Настанд чиглэсан ўлд ажиллагах явуудаг терийн бус байгууллагуудын тоо хүрээ засалтгээ, настад засалт үзүүлэх үйчинтэзүүллийн тоо, терөл нэмэгдэнэ. | Байгуулсан төв, клуб, байгууллын тоо, үйчинтэзүүллийн хүрээ | ХАХНХЯ | ЭМЯ, ЭЗХЯ, ГҮТ, төвшинд Япон, БНСУ, Австралия эзрэг орнуудад 10 хүний бурагдахуунтай хийнэ. (Жил болгон) | Тасралттай зувлух байгуулсан төв хүрээ орнуудад 10 хүний бурагдахуунтай хийнэ. (Жил болгон) | 2377.4 | |
| 3.8 | Настанд зориулсан газарыг байгуулах | 2016-2020 | Настанд зориулсан асрамжийн үйчилгээг өрөххүүзэх зорилгоор асрамжийн газрыг байгуулсаныар настанд үзүүлэх асрамжийн үйчилгээний хүртээмж, чанар сайнйина. | Настанд зориулсан асрамжийн үйчилгээний нэр, терөл тоо | ХАХНХЯ, ЭЗХЯ | Асрамжийн газар 2 жилд 1-ийг зувлух | | Нийтийн хамгийн сан, бусад эх туссар | |
| 3.9 | Настанд гэрээрд үзүүлэх тусамж, үйчилгээний зардлыг санхүүхүүлэх эрх зүйн орчинг бий болгох | 2016-2020 | Настнууд хөрөцээ шаардлагатадаа нийцсан туслахийг гэрээр авах боловж бураэнэ. | Гэрээр үзүүлэх тусамж, үйчилгээний санхүүхүүлтийн хэмжээ | ХАХНХЯ | ЭМЯ, НХҮГ, НДЕГ | 11 хүний бурагдахуунтай байгуулж, хувьц орнуулах саналыг боловсруулж баттуулна. | 35.1 | |



Зорилт 4. Эрүүл мэндийн цогц туслаамж үүчинчлэгээ настны хэрэгээ шаардлагад нийцүүлэн өргөхүүлэх

| 4.1 | Улсын хамжанд настанд эрүүл мэндийн туслаамж, үүчинчлэгээ настны хэрэгээ шаардлагад нийцүүлэн өргөхүүлэх | 2014-2020 | Наастанд узүүлж эрүүл мэндийн туслаамж үүчинчлэгээ шаталыг бортолсронгуй болно. | Үйл ажиллагааны нийтийн төрөл, онцлог, хүртээмж боловсруулж багтуулж нараажин арга зүйн удирдлагагаар эрүүл мэндийн байгуулалтуудыг хангах (хөгжлийн хугацаанд жил бүр явуулна) | ЭМЯ СЯ | ГҮТ ЭЭХЯ | >хөгжлийн стандарт, журам, удирдамж, эрх зүйн актыг боловсруулж нараажин арга зүйн удирдлагагаар эрүүл мэндийн байгуулалтуудыг хангах (хөгжлийн хугацаанд жил бүр явуулна) |
|-----|--|-----------|--|---|--|--|--|
| 4.2 | Үндэсний түвшинд лавлагаа туслаамж үзүүлэх Геронтологийн Ундааныг төвийн шиний барилгыг ашиглалтад оруулж, шаардлагатай тоого төхөөрөмжөөр ханган ажилтуулах | 2014-2018 | Наастанд геронтологи, гериатрийн чиглэээрх оруулсан барилга "-Тоног төхөөрөмжийн тоо | -Ашиглалтад оруулсан барилга "-Тоног төхөөрөмжийн тоо | ЭМЯ, СЯ | ГҮТ 7236.5 | Тус бүр 7 ширэгээ СТ, MRI, доплер, рентген, 3D эхо, эхийн эх, биомеханик, нийтийн суралт, иммунологийн, багаж, лабораторийн бараж, тоигот төхөөрөмж, уралж |
| 4.3 | Геронтологи, гериатрийн Мэдээлэлээр хүний нөхцлийн чадахийг дээшүүлэх суралтуухаа зөхисн багцүүлж, суралтуухаа | 2014-2020 | Наастанд эрүүл мэндийн туслаамж үүчинчлэгээ чанартай, оногийн хувьдэлүүлж авнаа. Геронтологийн Учээсний лавлагатай төвийн үзүүлэх туслаамж үүчинчлэгээний нийтийн нийгэлдээж, туслаамж үүчинчлэгээний чанар санжирч, чилжилж ажиллагаа болжин. | Суралцааж төгссөн эмзэглийн мэргэжлийн тоо | СЯ, ГҮТ ЭМЯ, ЭМХТ, Эрүүл мэндийг дамжуулсан, Тарийн сан | СЯ, ГҮТ 787.6 | Жил бүр Австрали, Япон, БНСУ-д мэргэжлиүүлэх болон давтсан сургалтад хилд б хийнг ханруулах |
| 4.4 | Аймаг дүүргийн нэгдсэн эмзэглийн гериатрийн кабинетийн чилжилтийн чанар туслаамж үүчинчлэгээ настганд узүүлэх эрүүл мэндийн туслаамж үүчинчлэгээг анхан ба 2 дахь шаталад. Узүүлж эрүүл мэндийн туслаамж үүчинчлэгээний чанар сэйжирна. Наастанд узүүлж эрүүл мэндийн туслаамж үүчинчлэгээний чанар шаталыг бортолсно. | 2014-2020 | Анхан ба 2 шаталыг настны чиглэлээр маргацсан хүний нөхцөө бүрэн хангана. Наастанд узүүлж эрүүл мэндийн туслаамж үүчинчлэгээний чанар сэйжирна. Наастанд узүүлж эрүүл мэндийн туслаамж үүчинчлэгээний чанар шаталыг бортолсно. | ЭМХТ ГҮТ, ЭМЦИУИС, Аймаг дүүргийн мэргэжлийн тоо Суралцаан мэргэжлийн тоо | ЭМХТ ГҮТ, ЭМЦИУИС, Аймаг дүүргийн мэргэжлийн тоо Суралцаан мэргэжлийн тоо | ЭМХТ ГҮТ, ЭМЦИУИС, Аймаг дүүргийн мэргэжлийн тоо Суралцаан мэргэжлийн тоо | Жил бүр Төрийн санжийн санжийн төрөлжилтээр жилд 30 герийн эмч, 30 герийн сувилгийг сургана. |

| | | | | | | | |
|------------------------------|--|---|--|----------------|--|---|---|
| 4.5 | Геронтологи гериатрийн салбар өндөр хөжсөн орны түршлэгтэй газар дээр нь очиж гериатрийн багар судлах, танилцувах, аялан зохион байгуулах | 2014-2015 Геронтологи, гериатр өндөр хөжсөн орны түршлэгтэй судаж, ерийн оронд нуташулах боломж нийцлийг судаана. | Түршлэгтэй судалсан орны тоо | Эмч, СЯ | ЭМХТ, ГҮТ | Жил бүр Австрали, Япон БНСУ-д 9 хүний бүрэлдэхүүнтэй багийг явуулах | 63.4 |
| 4.6 | Геронтологи гериатрийн салбар өндөр хөжсөн орны түршлэгтэй газар дээр нуташулах | 2016-2018 Геронтологи, гериатр өндөр хөжсөн орны түршлэгтэй монголын түршлэгтэй судаж, улсыдаа нуташулах, хөрөгжүүлнээр настанд үзүүлэх, эргүүлж майданын чанбаа саижинна. | Нуташуулсан түршлэгтэй тоо, үр дүн | Эмч, ЭМХТ, ГҮТ | Эрүүл мэндийн бүх шатны байгууллагат | Жил бүр бодлогын залваж боловсруулах 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хасаг томинийг дон ажиллаана. | 283.3 |
| 4.7 | Эргүүл мэндийн V бүлгийн настанд Гэрээр Узувчийн олон мэдрэгийн багийн түслэлийн хамрах хүрэгтэй түслэлийн чаньгаа саижиртуулах | 2014-2020 Эргүүл мэндийн V бүлгийн настанд, Узувчийн гаруйн түслэлийн улзгилгээ сайжирч, шаардлагатайгүй эмнэлэгт хөвтэлт цөврүү, эмнэлгийн аялал болтура. | Гэрээр түслэлж авсан настны тоо | Эмч, ГҮТ | Эрүүл мэндийн анхан ба хөфөргүүр шаталын байгууллага | -Анхан, II, III шаталын эрүүл мэндийн байгууллага бүр настанд гэрээр түслэж узувчилэх багийт болох - Холбогдох дээжигжлийн аяллаахаа байгууллагын байгууллагын | 35.6 |
| 4.8 | Настанд зориуулсан хамт олонд тулгуурласан сэргээн засалтын төрөл бүрин хөтөрийн бий болгох, дэмжих, сургалчлах үйл аяллагааг зохион байгуулах | 2014-2016 Настандуудын шаардлагатайг эмнэлэгт хандант буурна, виччелж буурна. Настандуудын нийтийн ийдвх, ортолцоо сайжирна. | Нэмэгдсэн тоо, төрөл Хамгаалсан настны тоо | Эмч, ГҮТ | Ахмаддын байгууллага ТББ, Эрүүл мэндийн анхан ба шаталын байгууллага | Жилдийн байгууллага 3 жилийн түрүүж, дасгал баялагал, сэгтэл засал эмчилгээ, дамжих бүлэг зэрэг хэлбэрүүдийг бий болгох ХОТС-ийн хөржүүлэх жилийн аяныг зохион байгуулах, тайллан хүлээж авах, дунгах | 18.3 |
| Хөтөлбөрийн нийт төсвийн дүн | | | | | | | 15 651.8 (15 тэрбум 651 сая 800 мянган төгрөг) |



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 420

Улаанбаатар
хот

Цөм сүргийн үржлийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дундговь, Өмнөговь, Увс, Завхан, Булган, Говь-Алтай, Хөвсгөл, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий, Дорнод болон Төв аймгийн “Цөм сүргийн үржлийн аж ахуй” төрийн өмчтэй үйлдвэрийн газрыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны харьяа Малын удмын сангийн үндэсний төвийн орон нутаг дахь салбар болгон аж ахуйн тооцоон дээр ажиллуулсугай.

2. Дундговь, Өмнөговь, Увс, Завхан, Булган, Говь-Алтай, Хөвсгөл, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий, Дорнод болон Төв аймгийн “Цөм сүргийн үржлийн аж ахуй” төрийн өмчтэй үйлдвэрийн газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийг өр, авлагын хамт Малын удмын сангийн үндэсний төвд шилжүүлж, “Цөм сүргийн үржлийн аж ахуй” төрийн өмчтэй үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг зохих журмын дагуу дуусгавар болгох арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Х.БАТТУЛГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 423

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2014 оны хэмжээг тогтоох тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тус тус тогтоож, 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцдаг иргэд, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг тус тус 670 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 6 хувтай тэнцүү байхаар тогтоож, 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрүүл мэндийн даатгалын 2012 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 195 дугаар тогтоолыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

С.ЭРДЭНЭ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn

Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 3.25
Индекс: 14003